



Төв аймгийн олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын санаачилгын өдөрлөгийн тайлан

2015 оны 5 дугаар сарын 19-ны өдөр

ОУИТБС-ын Ажлын хэсэг, ажлын албанаас Төв аймгийн Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын өдөрлөгийг аймгийн ЗДТГ-тай хамтран 2015 оны 5 дугаар сарын 15-ны өдөр Зуунмод суманд зохион байгууллаа.

Зорилго нь эрдэс баялгийн салбарын талаарх орон нутгийн иргэдийн мэдлэг, ойлголтыг дээшлүүлэх, ОУИТБС-ын тайлангаар ил тод болсон мэдээллийг иргэдэд мэдээлэх, ил тод, хариуцлагатай уул уурхайн талаар нэгдсэн ойлголтыг бий болгох, дэд зөвлөлийн үйл ажиллагааг бэхжүүлэх, төр, хувийн хэвшил, иргэний нийгмийн харилцан ойлголцол хамтын ажиллагааг хөхиүлэн дэмжихэд оршиж байв.

Өдөрлөгт Улаанбаатар хотоос Ашигт малтмалын газар, Татварын ерөнхий газар, Авилгатай тэмцэх газар, Стандартчилал хэмжил зүйн газрын Сорьцын хяналтын алба, Монголын Уул уурхайн үндэсний ассоциаци, Монголын байгаль орчны иргэний зөвлөл, Төлсөн авснаа нийтэл эвсэл, ОУИТБС-ын ажлын албаны зохицуулагч, харилцааны мэргэжилтэн, мэдээлэл технологийн зөвлөх, санхүүгийн ажилтан зэрэг 12 хүний баг, бүрэлдэхүүнтэй оролцов.

Орон нутгаас Заамар, Баян, Баянжаргалан, Сэргэлэн, Жаргалант сумдын засаг дарга, ИТХ-ын тэргүүлэгчид, Төв аймгийн ИТХ-ын ажлын алба, Засаг даргын орлогч, Санхүү, төрийн сангийн хэлтэс, Хөгжлийн бодлогын хэлтэс, Байгаль орчны газар, Мэргэжлийн хяналтын газар гэх зэрэг 58 хүн оролцов. Компаниудыг төлөөлж Мондулаан трейд ХХК, Уул уурхайн үндэсний олборлогч ХХК зэрэг 8 компанийн төлөөлөл оролцов. Бүртгэлийг хавсаргав.

Арга хэмжээ товлосон цагаас 1 цагаар хоцорч 10 цагт эхлэв. Төв аймгийн Засаг даргын орлогч Ж.Төмөрчөдөр өдөрлөгийг нээж үг хэлэхдээ *“Төв аймгийн хэмжээнд эрдэс баялаг, уул уурхайтай холбоотой асуудал яах аргагүй тулгамдсан асуудлуудын нэг болоод байгаа. Бид Эрдэс баялгийн салбарт баримтлах бодлогоо боловсруулж аймгийн ИТХ-аар батлуулсан, одоо хэрэгжилтийг хангахаар ажиллаж байна. Энэ баримт бичгийн эцсийн зорилго бол хариуцлагатай уул уурхайг хөгжүүлэхэд чиглэж байгаа. Манай аймгийн иргэдийн дунд уул уурхай бол газар нутаг, иргэдийн үндсэн амьдралын хэв маяг буюу орлогод сөргөөр нөлөөлдөг гэсэн маш том ухагдахуун бий болчоод байгаа. Энэ утгаараа бид ашигт малтмал, газрын хэвлийтэй холбоотой хуулийн хэрэгжилтийг хангаж ажиллахад иргэдийн хүндхэн эсэргүүцэлтэй тулгардаг. Өнөөдрийн энэ өдөрлөг, уулзалтын ач холбогдол нь иргэдэд уул уурхайн салбарын талаар бодитой, зөв мэдээлэл өгч, уул уурхайн салбарын эдийн засагт оруулж буй хувь нэмрийг ойлгуулах ийм уулзалт болно гэж ойлгож байгаа. Ялангуяа манай олборлолт бүхий сумдаас иргэдийн төлөөлөл нилээд олноор ирсэн байна. Сум, орон нутгийн удирдлагууд мөн компаниуд өнөөдрийн энэ уулзалтанд нилээд ач холбогдол өгч оролцох ёстой. Одоо шинээр хайгуулын лицензийг Төв аймгийн газар нутагт олноор олгохоор бидэнд сонгон шалгаруулт явуулна гэж мэдэгдээд байгаа. Тэгэхээр та бүхэн энэ талаар бас асуух зүйл байвал сайн асууж, тодорхой мэдээлэлтэй болно гэдэгт найдаж байна.”* гэж онцлов.

Хөтөлбөрийн дагуу ОУИТБС-ын ажлын албаны зохицуулагч Ш.Цолмон, харилцааны мэргэжилтэн Б.Дэлгэрмаа, мэдээлэл технологийн зөвлөх Г.Ганбат, МУУҮА-ийн ажилтан Б.Энхжин, Төлсөн авснаа нийтэл эвслийн гишүүн Б.Баярмаа нар ОУИТБС-ын зорилго, зорилт, хэрэгжилт, үйл явц, ач холбогдлын талаар илтгэл тавив.

Удаагаар Ашигт малтмалын газрын мэргэжилтэн Н.Оюунцэцэг, Сорьцын хяналтын албаны улсын байцаагч Г.Лутсүх нар мэдээлэл хийх байсан боловч арга хэмжээ хоцорч эхэлсэн, илтгэлүүд удааширсан, Улаанбаатар хотод яаралтай ажил гарсан зэрэг шалтгааны улмаас уулзалтаас явав. Оронд нь ажлын албаны зохицуулагч Ш.Цолмон бэлдсэн илтгэлүүдийг нь уншиж танилцуулав.

Татварын ерөнхий газрын улсын байцаагч Н.Болорчимэг Төв аймагт тусгай зөвшөөрөл эзэмшигч компаниудын улсын болон орон нутгийн төсөвт төлсөн албан татваруудыг танилцуулав. Төв аймгийн Санхүү, төрийн сангийн хэлтсийн орлогын мэргэжилтэн Ц.Туул аймгийн хэмжээнд 2013-2014 онд улсын төсвөөс хүлээн авсан санхүүгийн дэмжлэг, түүний зарцуулалтыг тайлагнав /Илтгэлүүдийг хавсаргав/.

Төв аймгийн Заамар сумын Засаг дарга Д.Болормаа, Баян сумын Засаг дарга Б.Шинэгэрэл, Баянжаргалан сумын Засаг дарга Г.Дүүрэн, Жаргалант сумын Засаг дарга Д.Ганболд нар 2013-2014 онд уул уурхайн компаниудаас сум орон нутагт хүлээн авсан хандив, дэмжлэг, түүний зарцуулалтыг танилцуулав.

Компаниудыг төлөөлж Заамар суманд үйл ажиллагаа явуулдаг Мондулаан трейд ХХК ажлын байр, орон нутгийн худалдан авалт, хаалтын төлөвлөгөө сэдвээр илтгэл тавив.

Төгсгөлд нь аймгийн Байгаль орчны газрын мэргэжилтэн Я.Дашъяачил байгаль орчны нөхөн сэргээлт, зарцуулсан зардал сэдвээр танилцуулга хийснээр өдөрлөгийн нэгдүгээр хэсэг өндөрлөж, хоёрдугаар хэсэг буюу асуулт, хариулт, нээлттэй хэлэлцүүлэг өрнүүлэв.

Хэлэлцүүлгээс гарсан асуулт, санал, шүүмжийг хураангуйлбал:

- Баянжаргалан сумын иргэн Базаррагчаа дараах 2 асуултыг асуусан боловч хариулт өгөх мэргэжлийн байгууллагын төлөөлөл байхгүй байсан тул эргээд хариу өгөхөөр болов. Асуулт 1: Хайгуулын тусгай зөвшөөрлийг ашиглалтын тусгай зөвшөөрөл болгоход сум, орон нутгаас санал авахгүйгээр дээгүүрээ шууд шийдвэрлэсэн байдаг. Энэ хуулийг өөрчилж болох уу?
Асуулт 2: Гадаадын ажиллах хүчний квотыг Ашигт малтмалын тухай хуулинд 10 хувь гэсэн байдаг, гэтэл Засгийн газрын тогтоол гараад тэр нь 20, 25 бүр сүүлдээ 30 хүртэлх хувь болж өөрчлөгдөөд байна. Энэ байж болох уу? Хуулиас давсан тогтоол байж болох уу?
- Заамар сумын Засаг дарга Д.Болормаа: сум, орон нутагт нөхцөл байдал ижил байгаа. Хайгуулын лицензийг олгохдоо сум, орон нутгаас санал авна гэсэн байдаг. Гэтэл тэр саналыг 30 хоногийн дотор хүргүүлэх ёстой. Энэ хугацаа бол бодитой хугацаа биш юм аа.
- Баянжаргалан сумын Засаг дарга Г.Дүүрэн: Наад 30 хоног бол хэрэгжих боломжгүй ээ. Хуулинд сумаас биш аймгаас санал авна гэсэн байдаг. Тэгээд нэг л мэдэхэд тусгай зөвшөөрөл олгогдчихсон байдаг. Дараа нь харин сумаас санал авна гээд хэлэлцүүлэг зохион байгуулаад байдаг. Энэ бол ямар ч хэрэггүй үйл ажиллагаа юм. За дээр нь, байгаль орчны төлөвлөгөөний биелэлт дээр сумын Засаг дарга, байгаль орчны байцаагчийн дүгнэлтийг үндэслээд хайгуулын тусгай зөвшөөрлийг ашиглалтын болгоод байгаа. Хуучин хайгуул нь олон, ашиглалт нь цөөхөн байсан бол одоо ашиглалт нь олон,

хайгуул нь цөөхөн болоод байгаа. Хуулиа л өөрчлөхгүй бол бүх зүйл л дээрээ шийдэгдээд байна, сум орон нутаг ямар ч эрх мэдэлгүй, ийм байдалтай байна.

- Төлсөн авснаа нийтэл эвсэл Б.Баярмаа: 30 хоног бол бага хугацаа юм аа. Одоогийн энэ шуудан, харилцаа ямар билээ. Тиймээс манай иргэний нийгмийнхэн 45 хоног болгоё гээд санал тавиад байгаа. Компаниуд бол зориудаар 30 хоногийг нь дуусгах гээд албан тоотыг барьж, барьж байгаад хугацааг нь тулгаж өгдөг. Одоо бид ямар боломж байна гэхээр Ашигт малтмалын газарт хайгуулын тусгай зөвшөөрөл авах гээд өргөдөл гаргангуут нь тэр өргөдөл гаргасан жагсаалтийг сум, орон нутаг руу урьдчилсан байдлаар хүргүүлэх тийм л арга байна. Ашигт малтмалын газартай ярьж байгаад болж өгвөл ОУИТБС-ын ажлын албаны цахим хуудас дээр тусгай зөвшөөрөл авахаар өргөдөл гаргасан компаниуд, байршилыг ил тод болгох хэрэгтэй.
- Баянжаргалан сумын иргэн Базаррагчаа: Өмнө нь АМНАТ-ын 10% нь суманд ногддог байсан. Одоо гэтэл суманд ямар ч татвар, орлого үлдэхгүй байна. Тэгээд иргэд юу гэдэг вэ гэхээр суманд татварын орлого орохгүй юм бол газраа өгөөд яах юм бэ гэдэг.
- Аймгийн ИТХ-ын ажлын албаны дарга Эрдэнэдалай: Асуулт байна. Нэгдүгээрт, Засгийн газрын 2012 оны 222-р тогтоолоор байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээ, байгаль орчныг хамгаалах төлөвлөгөө, тэдгээрт оруулсан өөрчлөлт, зардлын 50%-г дансанд төвлөрүүлсэн байдал, зарцуулалт, буцаан төлөлтийн мэдээг аж ахуйн нэгж бүрээр иргэдэд мэдээлнэ гэж заасан байдаг. Тэгэхээр танай ОУИТБС-ын тайланд эдгээр мэдээллийн аль нь орж байна вэ? Хэдхэн тоо хэрэгтэй байгаа юм. Үүнд: хөндөгдсөн газар, түүний хэдэн хувьд нь техникийн болон биологийн нөхөн сэргээлт хийсэн, энд ямар зардал гарсан. Мөн байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай 2012 оны хуульд иргэдийн оролцоог хангана гэж оруулсан байгаа. Тэгэхээр танай дээр байгаль орчинтой холбоотойгоор 2012 оноос хойш иргэдийн оролцоог хэрхэн хангаж вэ гэсэн ямар судалгаа, мэдээлэл байна вэ? Хоёрдугаарт, лиценз авсан аж ахуйн нэгжүүдийн хэд нь үйл ажиллагаа явуулж байгааг хянах ямар судалгаа, тоо баримт байна вэ? Лиценз авчихаад зарах гээд суугаад байдаг компаниуд байдаг. Гуравдугаарт, та бүгдийн бэлдэж ирсэн номон дээр 2014 онд төв аймагт төлсөн татварыг 7,4 тэрбум гэжээ. Хойд талын задаргаа дээр нь 3,2 тэрбум гэсэн байна. Манай аймагт бол 3 орчим тэрбум төгрөг л уул уурхайгаас татварт төлөгддөг. Тэр 7,4 тэрбум гэсэн тоо хаанаас гарч ирээд байна вэ?
- МБОИЗ-ийн гишүүн Б.Батболд: Төв аймгийн дэд зөвлөлийг шинэчлэх хэрэгтэй. Тэгш оролцоог хангаж, үйл ажиллагааг эрчимжүүлэх саналтай байна.
- ОУИТБСАА зохицуулагч Ш.Цолмон: Төв аймгийн дэд зөвлөл, сумдын салбар зөвлөлийн талаар үдээш хойш хэлэлцэх байгаа. Тэр үед саналаа хэлэлцээд явъя. Байгаль орчны мэдээллийн тухайд Монгол улс сайн дураараа ОУИТБС-ын стандартаар шаардаагүй мэдээллийг ил тод болгож мэдээлдэг. Үүнд 50%-ийн барьцаа төлбөр, байгаль орчны зардал, уулын ажлын төлөвлөгөөний биелэлт, нөхөн сэргээлтийн тухай мэдээлэл байдаг. Харин түрүүний Ашигт малтмалын газрын мэдээлэл дээр уулын ажлын тайлангаа өгдөггүй компаниуд байдаг юм байна. Энэ бол ноцтой асуудал. Сум, орон нутгийн удирдлагууд үүний мөрөөр ажиллаж, олон нийтийн шахалт, шаардлага тавих нь зүйтэй.
- ОУИТБСАА мэргэжилтэн Б.Дэлгэрмаа: Тусгай зөвшөөрөл эзэмшиж буй аж ахуйн нэгжүүдийн хэд нь олборлолт эрхэлснийг манай ОУИТБС-ын тайлангийн бүтээгдэхүүн олборлолт, борлуулалтын мэдээнээс харж болно. 7,4 тэрбумын тухайд Төв аймагт тусгай зөвшөөрөл эзэмшдэг боловч өөр аймагт тусгай зөвшөөрөл эзэмшдэг өөр, өөр аймагт татвар төлдөг бол энэ тоог нэгтгэж харуулсан байна. Манай аудитын тулган баталгаажуулалтаар эдгээр мэдээлэл нарийвчлан задардаг байгаа.
- Мондулаан трейд ХХК-ийн Наваандовдон: ОУИТБС-ын тайлангаар тухайн компанийн борлуулалтын орлого, улсад болон орон нутагт төлсөн татваруудыг мэдээлдэг. Гэтэл манай иргэдийн мэдээллийг хүлээн авах байдал, уул уурхайн талаарх мэдлэг, хандлага ямар билээ? Шууд л ийм их орлоготой компани байна гээд л буруу ойлгох вий.

Компаниуд гэтэл ашигт малтмал олборлох гэж ямар их зардал гаргадгыг тэр бүр мэддэггүй. Тиймээс зардлыг ил тод болгох саналтай байна.

- ОУИТБСАА мэргэжилтэн Б.Дэлгэрмаа: ОУИТБС-ын тайлангийн бүтээгдэхүүн олборлолт, борлуулалтын мэдээ гэсэн хэсгийн олборлосон үнийн дүн гэдэг нь та бүгдийн ямар өртөгөөр олборлосныг асуугаад байгаа юм. Компаниуд харин борлуулсан үнийн дүнтэйгээ яг ижил бөглөж ирүүлээд байдаг.
- Мондулаан трейд ХХК-ийн Наваандовдон: Санхүүгийн хэллэгт үйлдвэрлэлийн зардал л гэсэн нэг ойлголт байдаг. Олборлосон үнийн дүн гэдгийг үйлдвэрлэлийн зардал гээд л биччих хэрэгтэй. Тэгвэл бид ойлгоно.
- Аймгийн ИТХ-ын ажлын албаны дарга Эрдэнэдалай: Дэд зөвлөлийг яаралтай шинэчлэн, сайжруулъя. Сумын түвшинд, аймгийн түвшинд аж ахуйн нэгжүүдийн хариуцлагыг нэмэгдүүлъя. Нөхөн сэргээлтийн асуудал дээр илүү анхаарал хандуулах хэрэгтэй байна. Иргэдийн хяналтыг сайжруулах. Газрын төлбөрөө бүрэн авч чадахгүй байна, үүнийг сайжруулах. Ер нь энэ уул уурхайн үйл ажиллагаа явагдсанаар суманд ямар өгөөжтэй юм, үүн дээр дүгнэлт өгөх хэрэгтэй.
- Заамар сумын иргэн Цогтгэрэл: ОУИТБС гэсэн энэ байгууллага иргэн, төр, аж ахуйн нэгжийг нэг ширээний ард суулган, хяналт тавих нэрийн дор иргэдийг төр, аж ахуйн нэгжтэйгээ хамтраад энэ баялгаа идээд дууслаа гэсэн юм руу биднийг түлхэн оруулчихлаа. Хэдэн төрийн албан тушаалтан, орон нутгийн иргэд, компаниудыг оролцуулан зөвлөл байгуулаад, нэг нь тайлан гаргасан болоод, түүнийг иргэдэд мэдээлсэн болоод, иргэд нь оролцсон болоод ингээд ил тод байдлыг бий болгож байна гэвэл энэ нь дүр эсгэсэн төдий болох юм. Бид жинхэнэ утгаар нь ил тод байдлыг авч хэлэлцье гэвэл хэнд, хэзээ, ямар шийдвэрээр, юунд үндэслэн тусгай зөвшөөрлийг олгож байгааг ил тодоор ярих хэрэгтэй. Суманд байгаа байгаль орчны байцаагчийн ур чадвар, чадамж хүрэхгүй байна. Харин та бүгд энэ хүн чинь ажлаа хийж чадахгүй байна, энэ хүнийг ажиллуулъя гээд чадвартай хүнийг нь олж авчрах, холбож өгөх талаас нь анхаарч, ажлыг урагшлуулахад суман дээр очиж ажиллавал сайн байна. Аймгийн дарга нар сумын иргэд, удирдлагууд та бүгд хариуцлагатай ажиллаарай л гэх юм. Бид Заамар суманд хөндөгдсөн газрыг иргэд зохион байгуулалтанд ороод 9 сар нөхөн сэргээлт хийгээд сайн ажиллаж байсан. Гэтэл сайн ажиллаж байхад нь таслан зогсоочоод, муу юм болохоор бид нар аймагт байна, та бүгд сайн ажиллаарай гээд суух нь учир дутагдалтай. Манай сумын зөвлөл нэг удаа хуралдсан, тэнд хүмүүс ажил хийе гэж очоогүй, нэг хуралдсан болоод тарсан. Компаниуд ч энийг хийе, тэрийг тэлье гэж санаачлагатай оролцоогүй. Энэ байдлыг сайжруулах хэрэгтэй. Ингээд эцэст нь хэлэхэд одоогийн энэ тулгамдсан асуудлуудыг шийдвэрлэхэд ил тод байдлыг зөвлөлийг ажиллуулахгүй бол газар нутаг, баялаг ухаад дуусна, иргэд бид хоосон, юу ч үгүй дуусахнээ гэдгийг хатуу анхааруулмаар байна.

Хэлэлцүүлгийн төгсгөлд ОУИТБС-ын Ажлын хэсгийн гишүүд, ажлын алба дэд зөвлөл, салбар зөвлөл байгуулах талаар, үйл ажиллагааг идэвхжүүлэх талаар зөвлөмж, чиглэл өглөө. Өдөрлөгийг хааж Аймгийн Засаг даргын орлогч Ж.Төмөрчөдөр үг хэлэхдээ “хариуцлагатай уул уурхайг эрхлэн явуулсан бол өнөөдөр сум, орон нутагт ийм зөрчил үүсэхгүй байсныг, цаашид талууд илүү харилцан ойлголцож, хамтран ажиллахыг уриалснаар” хэлэлцүүлэг өндөрлөв.

Уг өдрийн үйл явцыг орон нутгийн телевиз сурвалжлан мэдээлэв. Оролцогчдоос авсан асуумжаар өдөрлөгийн үйл ажиллагааг хангалттай – 70%, дундаж – 22%, хангалтгүй – 7% хувь гэж дүгнэсэн бөгөөд дараах саналуудыг илгээсэн байна.

- Үйл ажиллагаа явуулж байгаа уурхайнуудын нөхөн сэргээлтийг үндэслэж лиценз олгох шаардлагатай байна.
- Хамтарсан уулзалт ядаж жилдээ 2 удаа зохион байгуулах
- Үйл ажиллагаа явуулж буй алтны уурхайн дарга нарыг оролцуулах
- Ашигт малтмалын газрын дүгнэлт, лиценз гаргахдаа мөнгөний асуудал байна уу?

- Ашигт малтмалын шинэчилсэн хуулийг иргэдэд сурталчилах, алтны уурхай, ААН-үүдийн орлогыг ил тод нээлттэй болгох, ард иргэдэд БИНХ-аар тайлагнадаг байх
- Ил тод байдлын өдөрлөг энэ арга хэмжээг жилд 1-2 удаа орон нутагт зохион байгуулах
- Уулзалт зөвлөгөөний дараах үр нөлөөг дээшлүүлэх
- Ашиглалтын лицензийг иргэдийн саналыг харгалзан олгож уул уурхайн ил тод байдлыг бүрэн утгаар нь хэрэгжүүлэх, иргэдийг мэдээллээр байнга хангах
- Уул уурхайн зөвшөөрлийг зогсоох, хууль өөрчлөх, орд ашиглуулж байгаа суманд 50%-ийн нөөц ашигласны төлбөр авах
- Иргэдийн оролцоог нэмэгдүүлэх
- Иргэдэд хэлэлцүүлээгүй олгосон бүх зөвшөөрлүүдийг цуцлах, орон нутагт дахин хайгуул, ашиглалтын зөвшөөрөл олгохгүй байх
- Бүх мэдээллийг иргэдэд ойлгомжтой хүргэх
- Ийм өдөрлөг ойр ойрхон хийж байх нь зөв явдал болно
- Өдөрлөг болж байгаа нь зөв зүйтэй юм гэвч энд ярьсан үг хэр хол явах болоо
- Сумын нийт иргэддээ өнөөдрийн өдөрлөгийг зохион байгуулмаар байна.
- Хайгуул, ашиглалтын компаниудын эздийг мэдэж баймаар байна.
- Ашиглалт олгохдоо сумын иргэдээс санал авдаг баймаар байна.
- Хөтөлбөрт тусгасан үйл ажиллагаа, хариуцах талууд сонсгол мэдээллээ бүрэн өгөх талд доголдолтой байна.
- Тусгай зөвшөөрөл олгох үйл явц, хүчин төгөлдөр тусгай зөвшөөрөл зэргийн талаарх мэдээллийг сонссонгүй, албан хаагч нь ирсэнгүй.
- Ашигт малтмалын газрын мэргэжилтэнтэй санал солилцох асуух зүйл их байсан ч чадсангүй
- Талууд тэнцүү хэмжээгээр хариуцлагатай оролцох хэрэгтэй байсан. Дүр эсгэсэн өдөрлөг байлаа.
- Суманд нэмж лиценз гаргахгүй байх хэрэгтэй байна.
- Хяналтаа өндөржүүлж, иргэдэд мэдээллийг цаг тухайд хурдан шуурхай хүргэх, тогтмол мэдээлэл өгөх
- Тухайн яригдаж байгаа асуудлыг орон нутагт тогтмол баг, иргэдийн дунд ажил болгох нь чухал
- Лиценз нэмж гаргах хэрэггүй.
- Нөхөн сэргээлтийг маш сайн хийхийн хажуугаар бүтээн байгуулалт, зам, аялал жуулчлалд ихэнх хувийг зарцуулах, залуучуудыг ажлын байраар хангаж тухайн сумыг хүн ам олноор суурьшиж хотжих нөхцлийг бүрдүүлэх хэрэгтэй.
- Төв аймгийн Заамар суманд нөхөн сэргээлт хийлгүй хаяад явсан компаниудыг ил тод болгох, дахин уул уурхайд оруулахгүй байх
- Аймгийн дэд зөвлөл, сумын салбар зөвлөлийг ажлыг идэвхжүүлэх

Хянасан:

Ш.Цолмон

Тайлан бичсэн:

Б.Дэлгэрмаа